



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/378

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хуралдааны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан аймгийн Засаг даргын Тамгын газрын барилгын дээврийн засварын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Сэнгүн констракшн” ХХК-тай 226,333,756 (хоёр зуун хорин зургаан сая гурван зуун гучин гурван мянга долоон зуун тавин зургаа) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3.Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.


4.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Сэнгүн констракшн” ХХК-ийн захирал (Б.Намхайнямбуу)-д даалгасугай.

5.Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

6.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



6324010488

Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 24 ны/ний өдрийн А/378 дугаар
захирамжийн хавсралт

| д/д | Нөхцөл шаардлага | Мөнгөн дүн | Хариуцах албан тушаалтан |
|-----|--|--|---------------------------|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Магадлашгүй ажил | 3,600,169 | Ү.Бямбасүрэн |
| 2 | Захиалагчийн албаны зардал | 3,600,169 | Ү.Бямбасүрэн |
| 3 | Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал | 1,800,085 | Ү.Бямбасүрэн |
| 4 | Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн | 19,000,000 | Ү.Бямбасүрэн |
| 5 | Нормчлолын сан | 324,015 | Ү.Бямбасүрэн |
| 6 | Алданги | Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.05 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна. | Д.Батцогт |
| 7 | Чанарын баталгаа | Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана. | Д.Батцогт Ү.Бямбасүрэн |
| 8 | Ажил гүйцэтгэх хугацаа | Хуанлийн 45 хоног | Ү.Бямбасүрэн |